СЭЛЭНГЭ АЙМАГ ISO 9001 СТАНДАРТ ХЭМЖИЛЗҮЙН ХЭЛТЭС

**Хавсралт- 6**

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН
# 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2021 он 12 дугаар сарын 10

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **1** | **Зорилт-1.Төсөв санхүү бүрдүүлэх, нөөцийн бэлэн байдлыг хангах** | **Батлагдсан төсөв** | **Хэрэгжилтийн хувь** | **100** | **100** | Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс **200,182,500** төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого **71532900** төгрөгийг бүрдүүлсэн. Авлагын эхний үлдэгдэл **669,0** мянган төгрөгийг барагдуулсан. Өнгөрсөн онд ХХОАТ-ын **215,3** мянган төгрөгийг өр үүссэн байсныг төлж барагдууллаа. | 100 |
| 1.1 | Төсвийн орлогыг бүрдүүлэх | - | Орлогын биелэлт | 67 сая | 70 сая | 2021 оны 12 сарын 09-ны байдлаар **71532900** төгрөгийн орлого бүрдүүлсэн. Орлогын төлөвлөгөө-102.1% биелэв. | 100 |
| 1.2 | Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 3 фазын цахилгаан тоолуур шалгах төхөөрөмжийн талаарх судалгаа, тооцоог боловсруулж уламжлах, шийдвэрлүүлэх | - | Шийдвэрлэсэн хөрөнгийн хэмжээ | Эталон тоног төхөөрөмж байхгүй | 30 сая | Цахилгааны хэмжлийн лабораторийн өнөөгийн байдал, эталон тоног төхөөрөмж шаардлагатай байгаа судалгаа танилцуулга, шинээр авах төхөөрөмжийн техникийн хэмжилзүйн үзүүлэлт, шаардлагыг тусгасан танилцуулга, хүсэлтийг аймгийн ЗДТГ-т албан тоотоор хүргүүлсэн. | 30 |
| **2** | **Зорилт-2. Орон нутгийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд тохирлын үнэлгээний бодлогоор дэмжлэг үзүүлнэ.** | **11 сая** | **Дэмжлэг үзүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн тоо** | **15** | **20** | Сүхбаатар, Сайхан, Шаамар, Зүүнбүрэн сумын 10 иргэн, аж ахуйн нэгжийн **7 нэрийн 29 бүтээгдэхүүнийг** МХГ-ын Итгэмжлэгдсэн сорилтын лабораторит сорилт шинжилгээнд хамруулахын зэрэгцээ сав баглаа боодол, хаяг шошгыг холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн хийх талаар арга зүйн заавар зөвлөмж өгч ажиллав. | 100 |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1 | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй төрийн байгууллагууд болон аж ахуйн нэгжүүдэд ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | 1 сая | Сургалт, хэлэлцүүлгийн тоо | 1 | 1 | ISO 9001 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр зорьж буй аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Чанарын менежер Э.Наранбилэгт менежментийн тогтолцооны дотоод сургалт зохион байгуулах, дотоод аудит явуулах төлөвлөгөө хөтөлбөр, холбогдох дүрэм журам боловсруулах талаар **2 удаа** зөвлөмж өгч ажилласан. Мөн HACCP тогтолцоо нэвтрүүлэхээр зорилт тавиад ажиллаж буй Алтанбулаг сумын 3-р багт байрлах мал нядлах, мах боловсруулах “Хүчү-Агро” ХХК-ий үйлдвэрлэлийн байдалд тохирлын үнэлгээ хийж, “Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага MNS ISO 22000:2019” стандартаар ханган, аймгийн МХГ, ХХААГ-ын улсын байцаагч, мэргэжилтнүүдтэй хамтран үйлдвэртэй танилцан, арга зүйн зөвлөмж өгөх арга хэмжээг зохион байгуулсан. | 100 |
| 2.2 | Аймгийн хэмжээнд “Чанарын чуулган” зохион байгуулж, “Чанарыг эрхэмлэгч байгууллага” шагналыг бий болгон хэрэгжүүлнэ. | 10 сая | Шалгарсан байгууллагын тоо | - | 2 | Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/362 тоот захирамжаар “Чанарыг эрхэмлэгч байгууллага” шагналыг олгох журам батлуулсан. Ковидын нөхцөл байдлаас шалтгаалан Чанарын чуулган хийх хугацааг хойшлуулсан. | 50 |
| 2.3 | Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой аж ахуйн нэгжид зориулсан сургалт, мэдээллийн арга хэмжээг зохион байгуулах | - | Сургалтын тоо | - | 1 | “MERCY CORPS” ОУБ-ын Сэлэнгэ аймаг дахь суурин төлөөлөгчтэй хамтран Алтанбулаг, Зүүнбүрэн, Сүхбаатар суманд мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Хүчү Агро”, “Болор Эмүүн”, “МБӨ” ХХК-ий 12 ажилтанд “Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тохирлын үнэлгээ, баталгаажуулалт хийх нь”, “Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шаардлага MNS 5023:2001”, “Хэмжил зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай” сэдвээр цахим сургалт хийсэн. | 100 |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **3** | **Зорилт 3. Тохирлын баталгаанд хамрагдах бүтээгдэхүүн ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОО ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ** | **-** | **Тохирлын баталгаанд хамрагдсан бүтээгдэхүүн, үйлчилгээ** | **243/4** | **240/6** | 13 сумын **274** аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд холбогдох стандартын дагуу тохирлын үнэлгээ хийсэн бөгөөд стандартын шаардлага хангасан **263** үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээ олгосон. Үүнд: хүнсний мухлаг-**7**, хүнсний дэлгүүр-**144**, ая тухтай дэлгүүр-**2**, минимаркет-**21**, супермаркет-**1**, кафе-**8**, зоогийн газар-**13**, караоке баар-**19**, кейтерингийн үйлчилгээ-**2**, цайны газар-**12**, худалдааны агуулах-**1**, дэн буудал-**2**, зочид буудал-**2**, амралтын газар-**7**, үсчин-**8,** авто сэлбэг-**2**, махны мухлаг-**4**, гэрэл зургийн студи-**1**, төрөл бүрийн бараа-**3**, гоо сайхны салон-**2**, халуун ус-**1**, супермаркет-**1** үйлчилгээний газруудыг баталгаажуулж 12 дугаар сарын 07-ны байдлаар **33927.0** мян төгрөгийн өссөн дүнгээр орлого бүрдүүлж ажилласан. | 100 |
| 3.1 | Бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон үйлчилгээний байгууллагад зориулсан сургалт зохион байгуулах | - | Зохион байгуулах сургалтын тоо | 2 | 2 | Сумдын 23 үсчин гоо сайханчдад "Үс засах үйлчилгээнд тавих шаардлага MNS 5160:2020", "Гоёлын гоо заслын үйлчилгээ ерөнхий шаардлага MNS 5567:2006", Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ Хумс заслын үйлчилгээ, ерөнхий шаардлага MNS 6843:2020" стандартын талаар сургалт зохион байгуулж, мэдээлэл өгсөн. Сумдын цэцэрлэг сургуулийн тогооч нярав **28** ажилтныг хамруулан "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага MNS 4946:2019" стандартын сургалт хийсэн. | 100 |
| 3.2 | Заавал баталгаажуулалтад хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | - | Тохирлын баталгаанд хамрагдсан бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийн тоо | 4/7 | 6/10 | Ерөө, Сүхбаатар, Сайхан, Мандал, Алтанбулаг сумын 9 аж ахуйн нэгж, иргэний **6** нэрийн **13** бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн байдалд холбогдох стандартын дагуу тохирлын үнэлгээ явуулж, баримт бичгийн бүрдэлд дүн шинжилгээ хийж, тохирлын гэрчилгээ олгосон бөгөөд бүтээгдэхүүний баталгаажуулалтын орлого жилийн эцсийн байдлаар **1879,8 сая/төг**-ийг бүрдүүлсэн. | 100 |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **4** | **Зорилт-4. Иргэд, хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн төрийн үйлчилгээг тасралтгүй хүргэх зорилгын хүрээнд ISO 9001 стандартын шаардлагад үргэлжлэн нийцэж ажиллах** | **-** | **Стандартын хэрэгжилтийн хувь** | **85** | **88** | Байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн Чанарын менежментийн тогтолцооны байнгын сайжруулалтыг ханган, иргэд хэрэглэгчдэд ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан цахимаар үйлчилгээ авах хүсэлтээ ируүлж, шийдвэрлүүлэх боломж нөхцлийг бүрдүүлэн, үйлчилгээ авах талаарх санал хүсэлтийн 40-50%-ийг цахимаар хүлээн авч шийдвэрлэн ажилласан. | 100 |
| 4.1 | ISO 9001 стандартын дагуу дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээг зохион байгуулах | - | Дотоод аудит, Удирдлагын дүн шинжилгээний тоо | 2/1 | 2/1 | Байгуулуулагын дотоод аудитын төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу **<u>2 аудит</u>** хугацаандаа хийгдсэн. Дотоод аудитаар том үл тохирол илрээгүй, аудиторуудын өгсөн зөвлөмжийн дагуу холбогдох сайжруулалтууд цаг хугацаандаа хийгдсэн. | 90 |
| **5** | **Зорилт-5. Байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэд, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, мэдээ, мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хангах** | **-** | **Мэдээ, мэдээллийн тоо** | **64** | **72** | Сэлэнгэ стандарт, хэмжил зүй фэйсбүүк хуудсанд хэмжил зүй-**13** мэдээлэл,    Баталгаажуулалт-**13**, стандарт, сургалт -**55**, ковид-19 цар тахалтай холбоотой- **77**, хууль тогтоомжийн **5** мэдээ мэдээллийг байршуулсан бөгөөд masm.gov.mn сайтын сэлэнгэ аймаг хэсэгт **62** мэдээлэл бэлтгэн оруулсан. | 100 |
| 5.1 | Хэрэглэгчээс сэтгэл ханамжиийн судалгаа авч дүн шинжилгээ хийнэ | - | Хэрэглэгчийн сэтгэл ханамж хувиар | 85 хувь | 88 хувь |  Хэлтсийн вэйб сайт, пэйж хуудас болон, санал асуулгын хуудсаар 9 сумын 132 иргэд хэрэглэгчдээс санал асуулга авч, үр дүнг нэгтгэн хавсаргав. | 100 |
| **6** | **Зорилт-6. Салбарын тэмдэглэлт өдрийн арга хэмжээг зохион байгуулж, үйл ажиллагаа сурталчлах** | **2 сая төгрөг** | Төлөвлөгөөний биелэлт | 90 хувь | 92 хувь | “Дэлхийн хэмжил зүйн өдөр”, “Дэлхийн Чанарын өдөр”, “Дэлхийн Стандартын өдөр”-ийн уриа, холбогдох мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, иргэд хэрэглэгчдэд сурталчлах ажлыг хийсэн.  | 70 |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.1 | “Дэлхийн хэмжил зүйн өдөр”, “Дэлхийн итгэмжлэлийн өдөр”, “Дэлхийн стандартын өдөр”, “Дэлхийн чанарын өдөр” арга хэмжээг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх | 2 сая төгрөг | Төлөвлөгө өний биелэлт | 90 хувь | 92 хувь | СХГ-аас зохион байгуулсан “Дэлхийн хэмжил зүйн өдөр”-т зориулсан семинарт цахимаар тус хэлтсийн 4 албан хаагч хамрагдаж мэдээлэл авсан. “Дэлхийн Стандартын өдөр”, “Дэлхийн хэмжил зүйн өдөр”-ийг тохиолдуулан аймгийн ЗДТГ, Боловсролын газартай хамтран 2021.10.20-2021.11.17-ийг хүртэл ЕБС-ийн сурагчдын дунд “Чанарыг эрхэмлэх нь” гар зургийн уралдаан зохион байгуулж, тэргүүлсэн сурагчдад, өргөмжлөл, мөнгөн шагнал олгосон.    | 100 |
| **7** | **Зорилт-7. Хэмжил зүйн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх** | **-** | **Хуулийн хэрэгжилт ийн хувь** | **100** | **100** | Хэрэглэгч үйлчлүүлэгчид мэдээллийг тухай бүр өгч, Хэмжилзүйн тухай хуулийн цуврал мэдээллийг 10 удаа пэйж хуудсаар дамжуулан түгээж, байгууллагынхаа вэйб сайтыг шинээр ашиглалтанд оруулж, мэдээлэлүүдийг бүрэн байршуулахад анхааран ажилласан. | 100 |
| 7.1 | Ажлын эталоныг бий болгох, хадгалах, ашиглах, тэдгээрийн нэгж дамжуулалтыг хангах; | Томилолт, тээвэрлэлтийн зардал | Эталоны тоо | 55 | 30 | Стандарт, хэмжилзүйн газрын Хэмжилзүйн хүрээлэнтэй 2021 онд эталон хэмжих хэрэгслээ шалгалт тохируулгад хамруулах гэрээ, графикаа байгуулсан. Түүний дагуу нийт **35** ш хэмжих хэрэгслээ шалгалт тохируулгад хамруулаад байна. | 100 |
| 7.2 | Хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийх | 5 ажилтны урсгал зардал | . Төлөвлөгөөний биелэлт | 5021 ширхэг | 4800 | Хэмжүүр баталгаажуулалтын тоо, орлогын төлөвлөгөөний дагуу **2721** ш хэмжих хэрэгсэл баталгаажуулж**, 32639,7** мян.төгрөгний орлого бүрдүүлээд байна. Урьд оны авлага **733,0** мян.төгрөгийг барагдуулсан байна. Хэмжилзүйн орлого, тоо хэмжээ буурсан үзүүлэлттэй байгаа нь цар тахал хөл хорионоос үүдэн, мөн тодорхой бус шалтгааны улмаас механикийн төрлөөр бүх сумдад ажиллахаас 3 суманд ажиллаагүй, цахилгаан хэмжлийн төрлөөр баталгаажуулалт хоорондын хугацаанаас хамаарч төлөвлөлт биелэх боломжгүй байна. Тоо хэмжээний биелэлт- 56,6 %, орлогын биелэлт-85,8% байна. | 70 |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7.3 | Хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийх | 5 ажилтны урсгал зардал | Төлөвлөгөөний биелэлт | 80 | 60 | Аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээний дагуу шалгалт тохируулгын ажлыг гүйцэтгэж, эзлэхүүний хэмжээт сав 12 ш, уртын хэмжлийн 3, массын хэмжлээр 47 электрон жин, 114 ш туухайнд нийт **176** хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулгын гэрчилгээ олгож, **1362,1** мян.төгрөгний орлого бүрдүүлсэн.<br>Тоо хэмжээний биелэлт-293 %, орлогын биелэлт-149,7 %<br><br> | 100 |
| 7.4 | Хэмжил зүйн ажлын эталоны нэр төрлийг нэмэгдүүлнэ. | 35.0 сая төгрөг | - | 2 эталон | 2 | Хэмжилзүйн лабораторит шинээр джитал штанген багаж, термометр, секундометр, уртын хэмжүүр авч лабораторийн эталон хэмжих хэрэгслийг сайжруулсан. Шаардлагатай эталон тоног төхөөрөмжийн судалгаа, тооцоог гаргаж, аймгийн Засаг дарга, СХГ-ын даргад санал уламжлав.   | 30 |
| **8** | **Зорилт-8. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх** | **-** | **Хуулийн хэрэгжилтийн хувь** | **100** | **100** | Стандартчилал, техникийн зохицуулалт тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган **62** аж ахуй нэгж, байгууллага, иргэний захиалгын дагуу **249** стандарт борлуулж, холбогдох стандартын шаардлага хангасан **274** аж ахуй нэгж, иргэний **263** үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээ олгосон байна. | 100 |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8.1 | Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт хийх | 2 ажилтны урсгал зардал | Баталгаажуулсан бүтээгдэхүүн үйлчилгээний тоо, | 4/243 | 6/240 | Ерөө, Сайхан, Сүхбаатар, Мандал сумын 5 аж ахуйн нэгж, иргэний 3 нэрийн 13 бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн байдалд холбогдох стандартын дагуу тохирлын үнэлгээ явуулж, баримт бичгийн бүрдэлд дүн шинжилгээ хийж тохирлын гэрчилгээ олгосон бөгөөд бүтээгдэхүүний баталгаажуулалтын байдлаар **1879,8 мян/төг**-ийг бүрдүүлж ажиллалаа. | 100 |
| 8.2 | Стандарт, техникийн зохицуулалтын улсын мэдээллийн салбар санг ажиллуулах | 1 ажилтны урсгал зардал | Хүсэлтийн биелэлт-100 хувь, орлогын төлөвлөгөө-100 хувь | 88 иргэн, аж ахуйн нэгжид 106 стандарт борлуулсан. Орлого 1620,0 мян.төг | 120 ш стандарт борлуулж, 1.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэх | Стандартын мэдээллийн салбар сангаас 68 аж ахуй нэгж, байгууллага, иргэнд 203 нэрийн 270 стандартын талаар мэдээлэл, арга зүйн зөвлөмж өгч, **62** аж ахуй нэгж, байгууллага, иргэний захиалгын дагуу **197** нэрийн **249** стандарт борлуулж, **3086404** төгрөгийн орлого бүрдүүлсэн. Дотоод албан хэрэгцээнд 20 нэрийн 21 стандарт, хэвлэн олгосон. Мөн аймгийн онцгой комиссийг Хөдөлмөрийн эрүүл мэнд, цар тахлын үеийн MNS ISO 45005:2021 стандартаар хангаж, арга зүйн зөвлөмж өгч, 17 сумын онцгой комисс, онцгой байдлын газарт стандартыг үнэ төлбөргүй олгосон. | 100 |
| 8.3 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад стандарт боловсруулах талаар арга зүйн зөвлөгөө өгөх | 1 ажилтны урсгал зардал | Хүсэлтийн биелэлт | 100 | 100 хувь | Байгууллагын стандарт боловсруулах талаар хүсэлт ирээгүй. | - |
| 8.4 | Стандарт, тохирлын үнэлгээний чиглэлээр сургалт зохион байгуулах | Сургалт, арга хэмжээний зардал | Зохион байгуулсан сургалтын тоо | 5 | 2 | “Мерси корпс” ОУБ-ын Сэлэнгэ аймаг дахь суурин төлөөлөгчтэй хамтран мах махан бүтээгдэхүүний үйлдвэр, худалдаа эрхлэгч **3** аж ахуй нэгжийн **12** ажилтанд “Мах, махан бүтээгдэхүүн. Эрүүл ахуйн аюулгүй байдлын үндсэн шаардлага MNS 5023:2001” стандартын талаар мөн сумдын **23** үсчин гоо засалчдад “Гоёлын гоо заслын үйлчилгээнд тавих шаардлага MNS 5567:2006” стандартын талаар сургалт хийсэн. Сумдын сургууль цэцэрлэгчийн **29** тогоочдод “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага MNS 4946:2019” стандартаар сургалт, мэдээлэл хийсэн. | 100 |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | **Зорилт-9 . Сорьцын хяналтын дүрмийг хэрэгжүүлэх** | **-** | **Дүрмийн хэрэгжилт** | **100** | **100** | Сорьцын хяналтын дүрмийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, холбогдох хяналт шалгалтыг аймгийн ЗДТГ, ХЭАХН, СХГ-тай хамтран **2** удаа зохион байгуулж, 96 ш мөнгөн аяга, үнэт эдлэлд хэмжилт хийн, үр дүнгээр зөвлөмж чиглэл өгсөн. | 100 |
| 9.1 | Сорьцын хяналт шалгалт хийх | 1 ажилт-ны урсгал зардал | Хяналт шалгалтын тоо-2 | 2 | 2 | Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулдаг үнэт эдлэл худалдан борлуулж байгаа 6 худалдаа эрхлэгчдэд “Сорьцын хяналтын чиг үүрэг”, “MNS 6505:2015 Мөнгөн аяга.  ерөнхий шаардлага” стандарт, хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын ач холбогдлын талаар мэдээлэл өгч сорьцын баталгаа болон мөнгөн аяганы үзүүлэлтүүдэд 2 удаагийн хэмжилт, шалгалт хийж, шалгалтын үр дүнгээр нийтлэг зөрчил болох хаяг шошго байхгүй сорьцын баталгааны тэмдэггүй, шошгонд хэмжээ тавиагүй нийтлэг зөрчлийг илрүүлэн худалдаа эрхлэгч, иргэн нэгжид СХЗГ-ын үнэт металын сорьцын хяналтын газраас ирүүлсэн үнэт эдлэл худалдан борлуулагчдад өгөх зөвлөмжөөр ханган, илэрсэн нийтлэг зөрчлүүдийг арилгуулах хугацаатай албан даалгавар өгч, стандартаар хангаж ажилласан. Мөн СХГ-ын Сорьцын хяналтын газрын даргатай хамтран үнэт эдлэл худалдан борлуулдаг 2 лангуу, 1 дэлгүүрийн 75 ш мөнгөн аяга, үнэт эдлэлийн жин, шошго зэрэгт хэмжилт хийн, зөвлөмж өгсөн. | 100 |
| **10** | **Зорилт-10. Хуулиар олгогдсон нийтлэг чиг үүргийн хэрэгжилт** | **-** | **Хуулийн хэрэгжилт ийн хувь** | **100** | **100** | Байгууллагын үйл ажиллагаанд төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдлөг болгон ажилласан. Хүний нөөцийн бүрдүүлэлтэд Төрийн албаны тухай хууль тогтоомжийг мөрдөн, аймгийн ТАСЗ-д сул орон тооны захиалга өгч, журмын дагуу иргэнийг томилсон. | 100 |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10.1 | Орон нутгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсүүдийн үйл ажиллагааг салбарын бодлого, зорилт, Засгийн газар холбогдох дээд шатны байгууллагын шийдвэртэй уялдуулах, зохицуулах, зохион байгуулах | - | Хамрагдсан хурал, зөвлөгөөний тоо | 6/2 | Тухай бүр | Стандарт, хэмжил зүйн газраас цахимаар зохион байгуулсан хурал семинарт 2 удаа хамрагдсан. Мөн 2021 оны 01 дүгээр сард СХГ-ын дарга Б.Билгүүнтэй цахимаар холбогдож байгууллагын үйл ажиллагааг танилцуулан, шийдвэрлэх шаардлагатай асуудлын талаар танилцуулсан. СХГ-ын хяналт шинжилгээний үнэлгээний ажлын хэсэг 2021 оны 10 дугаар сарын 05-нд хэлтсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, заавар зөвөлгөө өглөө. Түүний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулан хэрэгжилтийн тайланг хүргүүлсэн.  | 100 |
| 10.2 | СХЗГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу өөрийн үйл ажиллагааны гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх | - | Удирдамжийн хэрэгжилтийн хувь | 100 | 100 | СХЗГ-ын “Хяналт, шинжилгээ-үнэлгээний журам”-ын дагуу байгууллагын үйл ажиллагааны эхний хагас жилийн болон жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд хяналт, шинжилгээ үнэлгээг холбогдох журмын дагуу хийж, тайланг хүргүүлэв. | 100 |
| 10.3 | Хүний нөөцийн удирдлагын манлайлалыг хангах, нийгмийн баталгааг хангах, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх | - | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 100 | 100 |  Коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын ажилтнуудыг халдвар хамгаалллын нэг удаагийн хамгаалах хэрэгслээр тогтмол хангаж, байгууллагын байр, ажиллах орчин нөхцлийг долоо хоног бүр ариутгаж, халдваргүйжүүлсэн. Мөн хэлтсийн 2021 оны сургалтын төлөвлөгөөний дагуу дотоод **8** сургалтанд **57** ажилтан, зорилтот **26** сургалтанд **85** ажилтан тус тус хамрагдсан байна. Мөн байгууллагад ажиллаж байсан **6** ахмад ажилтан, ажиллаж байгаа **2** албан хаагчийн шагналын тодорхойлолт, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг дарга, СХГ-т хүргүүлж, **1** ахмад ажилтан “Хөдөлмөрийн хүндэт медаль”, **1** ажилтан “Стандарт хэмжил зүйн салбарын тэргүүний ажилтан”, **1** ахмад ажилтан “Санхүү нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулсан.  Хэлтсийн албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулахад анхаарч **820** мян.төгрөгөөр засвар үйлчилгээ, шаардлагатай цэвэрлэгээ, үйлчилгээний багаж, хэрэгсэл авсан. **5** албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгосон байна. | 100 |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **11** | **Зорилт-11. Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах** | **-** | **Мэдээ, мэдээллийг** | **64** | **72** | Masm.gov.mn цахим хуудсын Сэлэнгэ аймаг хуудаст байгууллагын танилцуулга, мэндчилгээ, үйл ажиллагаа, санхүү, хүний нөөцийн ил тод байдлын талаарх мэдээллийг бүрэн оруулж, нийт 62 мэдээлэл оруулан, тогтмол шинэчлэн ажиллав. Статистик мэдээллийг сар, улирлаар гарган сайтад байршуулан, мэдээллэв. Мөн Сэлэнгэ стандарт, хэмжил зүй фэйсбүүк болон фэйж хуудас ажлуулан, байгууллага, салбарын үйл ажиллагааны талаар 150 гаруй мэдээлэл байршуулав.  | 100 |
| 11.1 | Статистик мэдээ гаргах | - | Статистик мэдээ үнэн, зөв гаргасан тоо | 12 | 12 |  Хэмжил зүй, баталгаажуулалтын чиглэлээрх статистик мэдээг сар бүр нийт 22 удаа, стандартын салбан сангийн статистик мэдээг улирал бүр нийт 4 удаа, санхүүгийн мэдээллийг улирал бүр – 4 удаа нийт **30** удаа статистик мэдээг СХГ-т хугацаанд нь хүргүүлсэн. Мөн аймгийн Статистикийн хэлтэст улирал бүр 3 буюу нийт 3 удаа байгууллагын нэгдсэн статистик мэдээг хүргүүлсэн. | 100 |
| 11.2 | Үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах” | Сургалт, мэдээллийн зардал | Мэдээллийн тоо | 52 | 60 |  2021 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Сүхбаатар төмөр замын ажилтнуудад “Хэмжил зүйн тухай”, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн талаар танилцуулга сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, үйл ажиллагаагаа сурталчлав. Мөн байгууллагын фэйсбүүк, фэйж, хуудас, цахим хуудсаар дамжуулан үйл ажиллагаа, бусад шаардлагатай **150** мэдээлэл олон нийтэд хүргэн, цахим хуудсанд **62** мэдээлэл байршуулсан байна. | 100 |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **12** | **Зорилт-12. Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах** | **-** | **Хэрэгжилтийн хувь** | **100** | **100** | Байгууллагын төсөв, санхүүг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөн, зохион байгуулж, өр үүсгэлгүй ажилласан.<br>Хөрөнгө оруулалт байхгүй. | 100 |
| 12.1 | Байгууллагын хөрөнгө, санхүүгийн үйл ажиллагаар Төсвийн тухай хуулийн үндсэн зарчмуудтай нийцүүлэн зохистой удирдах Үүнд:<br>• СХХ-ийн 2022-2024 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх<br>• Улирал бүр СХХ-ийн батлагдсан урсгал зардлын төсвийн сарын хуваарьт өөрчлөлт оруулах<br>• СХХ-ийн 2022 оны урсгал зардлын төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөллийг боловсруулж дээд шатны байгууллагад өгөх | - | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Төсвийн тухай хуулийн дагуу байгууллагын санхүүгийн үйл ажиллагаар удирдан, зохион байгуулж ажилласан.<br>- Хэлтсийн 2022-2024 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулж, заасан хугацаанд нь СХГ-т хүргүүллээ.<br>- 1,2,3,4-р улирлын батлагдсан урсгал зардлын төсвийн дагуу сарын хуваарьт өөрчлөлт оруулан ажилласан.<br>- Тус хэлтэст 2021 онд нийт 200182500 сая төгрөгийн санхүүжилт авч, эдийн засгийн ангиллын дагуу анхан шатны баримтаар нотлогдсон ажил гүйлгээг үндэслэн, 175752419 төгрөгийг зарцуулсан байна.<br>- Төсөвт байгууллагын төлбөртэй ажил үйлчилгээнээс 71532900 төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөөг 100% биелүүлсэн. | 100 |
| 12.2 | Шилэн дансны мэдээллийг байршуулах | - | Мэдээллийн тоо, төрөл | 5/151 | 5/151 | Шилэн дансны мэдээллийн төрлөөр авч үзэхэд жилийн эцсээр байдлаар оруулах мэдээлэл- 5, Сар бүр оруулах мэдээлэл- 33, хагас жилээр оруулах-4,  улирал бүр оруулах мэдээлэл-3 тухай бүр оруулах мэдээлэл- 88 нийт **133** мэдээлэл байршууллаа. Үлдсэн мэдээллийн орох хугацаа болоогүй байна. | 90 |
| | Хэрэгжилтийн хувь | | | | | | 92,7 |